



МОНГОЛ УЛСААС ХОНКОНГТ НЭВТРЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ковид-19



- **12 ба түүнээс дээш насны** иргэд “Ковид-19” өвчний эсрэг **вакцины бүрэн тун (2 тун)**-д хамрагдсан байх (**Нислэгээс дор хаяж 14 хоногийн өмнө сүүлийн тунг** хийлгэсэн байна);
- Нислэгээс **өмнө 24 цагийн дотор түргэвчилсэн шинжилгээ (RAT)** өгсөн байх;
(Эрүүл мэндийн шалтгаанаар “Ковид-19” өвчний эсрэг вакцинд хамрагдаагүй бол энэ тухай нотолгоо (барим бичиг)-г харьяа эмнэлгээсээ гаргуулж авсан байх)



- “Сөрөг” хариутай иргэн Хонконгийн Эрүүл мэндийн газрын платформ <https://www.chp.gov.hk/hdf/> -д хандаж **бүртгүүлээд QR ногоон код** авсан байх;
- **Гар утсан дээрээ хадгалсан QR ногоон кодоо** Хонконгийн хилээр нэвтрэхдээ албаны хүмүүст **үзүүлснээр** таны мэдээлэл дотоодын эрүүл мэндийн системд орж баталгаажна. **Хилээр нэвтэрсэн даруйд** <https://www.evt.gov.hk/portal/en/> вебсайтын **Electronic Vaccination record** дэд цэсэнд хандаж, **өөрийн мэдээллээ баталгаажсан эсэхийг хянаарай**. Хэрэв таны мэдээлэл баталгаажсан бол **QR цэнхэр код** хуудасны **доод хэсэгт** гарч ирнэ. Энэхүү **QR цэнхэр кодыг LeaveHomeSafe** аппликейшн-д **суулгах шаардлагатай** бөгөөд уг аппликейшн нь Хонконгийн албан **байгууллага, үйлчилгээний газруудаар үйлчлүүлэхэд** танд хэрэг болно.



- Хонконгт **ирсэн эхний 3 хоногт хоолны газраар сууж үйлчлүүлэхгүй** байх. Зорчигч та Хонконгт **ирсэн эхний 7 хоногт түргэвчилсэн тестээр өөрийгөө шинжлээд** <https://www.evt.gov.hk/portal/en/> -д хандаж, **хариугаа өдөр бүр мэдүүлэх бөгөөд 1, 3, 5, 7 дахь хоногтоо PCR шинжилгээ заавал өгнө**.
(Хэрэв PCR шинжилгээ өгөөгүй, түргэвчилсэн тестийн хариуг өдөр бүр мэдүүлээгүй бол 25 мянган HKD-р торгох, эсхүл 6 сар хүртэл хугацаагаар баривчлах эрх зүйн зохицуулалттайг анхааруулж байна!)
(Түргэвчилсэн тестийг Хонконг дахь хүнсний сүлжээ дэлгүүр, эмийн сангуудаас худалдаж авах боломжтой ба PCR шинжилгээ өгөх газруудыг <https://www.communitytest.gov.hk/en/> үзнэ үү.)

Дэлгэрэнгүй мэдээллийг https://www.communitytest.gov.hk/en/?fbclid=IwAR1SeOItKrZ0UZp9B_Y-VdaF4Be8muo_J6709ZFYjdmHsfrsfCbUR5Np0 холбоосоор орж авна уу.